АШУҮИС

МОНГОЛ УЛСЫН СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ

# ТӨРИЙН ӨМЧИЙН 6 ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛУУДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны 12 сарын 10 өдөр | Дугаар А/249, А/253, А/270, А/195, А/230, А/313 | Улаанбаатар хот

**“Дусал цус- Дүүрэн амьдрал”**
**цус хандивлах аян зохион байгуулах тухай**

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалт, 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.35, 3.37, Төрийн өмчийн 6 их сургуулийн захирлуудын хамтарсан 2021 оны А/158, А/193, А/127, А/146, А/145, А/175 дугаар тушаалын 3.7 дахь заалт, АШУҮИС-ийн захирлын 2021 оны А/187 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Оюутны хөгжил хөтөлбөрийн 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн их сургуулиудын багш, ажилтан, албан хаагч, оюутнуудын дунд зохион байгуулах “Дусал цус - Дүүрэн амьдрал” цус хандивлах аяны хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Төрийн өмчийн их сургуулиудын багш, ажилтан, албан хаагч, оюутнуудын дунд “Дусал цус- Дүүрэн амьдрал” сайн дурын цус хандивлах аяныг хуваарийн дагуу бэлтгэл ажлыг ханган, халдвар хамгааллын дэглэмийг баримталж чанартай, үр дүнтэй зохион байгуулахыг төрийн өмчийн 6 их сургуулиудын тухайн асуудал хариуцсан ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Төрийн өмчийн их сургуулиудын багш, ажилтан, албан хаагч, оюутнуудын дунд “Дусал цус- Дүүрэн амьдрал” сайн дурын цус хандивлах аяныг зохион байгуулахад мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн хэрэгжүүлж буй “Оюутны хөгжил хөтөлбөр”, “Эх орончоюутан дэд хөтөлбөр”-ийн чиглүүлэгч (Д.Уранчимэг)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг төрийн өмчийн 6 их сургуулиудын тухайн асуудал хариуцсан дэд захирлуудад даалгасугай.

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Н.ХҮРЭЛБААТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Б.ОЧИРХУЯГ

ХӨДӨӨ АЖ АХУЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Т.ХЭРҮҮГА

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ДЭД ПРОФЕССОР О.АЛТАНГОО

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Б.ОЧИРБАТ

СОЁЛ УРЛАГИЙН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Э.СОНИНТОГОС

Төрийн өмчийн их сургуулийн захирлуудын
2021 оны 12.. дугаар сарын 10...-ны өдрийн
A/257, A/370 дугаар хамтарсан тушаалын хавсралт

A/249, A/230, A/313, A/195

“ДУСАЛ ЦУС - ДҮҮРЭН АМЬДРАЛ” ЦУС ХАНДИВЛАХ АЯНЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ

| **Д/д** | **Төрийн өмчийн их сургуулийн нэрс** | **Цус хандивлах аяны хуваарь** |
|---|---|---|
| 1. | Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль | 2021 оны 11 дүгээр сар;<br>2022 оны 05 дугаар сар |
| 2. | Монгол Улсын Их Сургууль | 2021 оны 12 дугаар сар |
| 3. | Хөдөө Аж Ахуйн Их Сургууль | 2022 оны 02 дугаар сар |
| 4. | Монгол Улсын Боловсролын Их Сургууль | 2022 оны 03 дугаар сар |
| 5. | Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль | 2022 оны 04 дүгээр сар |
| 6. | Соёл Урлагийн Их Сургууль | 2022 оны 05 дугаар сар |